

## ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**Илтгэгч:** 631-р дамжааны сонсогч

**П.Нямгарав Удирдсан**

**багш:** Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн багш, хошууч Г.Хатанбаатар

### Хураангуй

*Гамшиг - Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.*

*Хүмүүнлэгийн үйлчилгээгээр газар хөдлөлт, зуд, байгалийн гамшиг эсвэл хүн төрөлхтний өдөөсөн дайн, өлсгөлөнгийн үр нөлөө зэрэг гамшгуудад яаралтай хариу арга хэмжээ авч болно. Энэ нь мөн өвчлөлийг багасгах шаардлагатай болох гэх мэт хүн төрөлхтөний ноцтой бөгөөд өөрчлөхөд хэцүү хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн урт хугацааны хүчин чармайлтын нэг хэсэг байж болно.*

*Хүмүүнлэгийн үйлчилгээ нь хүмүүсийг илүү бие даах чадвартай болоход нь туслахаар дэлхий дээр явагдаж буй төслийг ивээн тэтгэх ажиллагаа.*

**Түлхүүр үг:** Хүмүүнлэгийн үйлчилгээ - хүмүүсийг илүү бие даах чадвартай болоход нь туслахаар дэлхий дээр явагдаж буй төслийг ивээн тэтгэх ажиллагаа.

Монгол оронд ямар нэгэн байгалийн гамшиг тохиолдоход бид олон улсын болон байгууллагуудаас хүмүүнлэгийн тусламж, туслалцаа дэмжлэг хүсэх нь зайлшгүй юм. Яагаад гэвэл хүмүүнлэгийн тусламж, туслалцаа нь гамшгийн үед аль ч улс орон бусад улс орнуудаас хүлээн авдаг гол бөгөөд анхан шатны тусламж юм.

“Гамшиг” гэдэг боол аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний амь нас хохирох, мал амьтан олноороо хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс орон нутгийн дотоод нөөц бололцооноос давсан хохирол учрахыг хэлнэ.

Гамшиг тохиолдсон үед ямар хоол хүнс, хангамж хэрэгтэй байгааг тодорхойлохоор орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнуудтай сүм хамтран ажилладаг. Шаардлагатай зүйлсийг тэр даруйд тухайн нутаг руу илгээдэг байна.

Гамшгийн аюулд нэрвэгдсэн орон нутгийн хүн амд амьдрах хэрэгсэл болгон үзүүлж байгаа үнэ төлбөргүй тусламжийг гамшгийн үеийн хүмүүнлэгийн тусламж гэнэ.

Хүмүүнлэгийн тусламжийг дотор нь:

1. Дотоодын
2. Олон улсын гэж ангилна.

Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна. Гамшгийн улмаас учирсан хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн дотоодын хүмүүнлэгийн тусламж хүсэх, уриалга гаргах шийдвэрийг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн

шатны Засаг дарга гаргана.<sup>27</sup>

Мөнгөн хөрөнгөөр үзүүлсэн дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Төрийн сангийн нэмэлт дансанд хүлээн авч бүртгэнэ. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ажлын хэсэг томилж дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг хүлээн авах, бүртгэх, байршуулан хадгалах ажлыг зохион байгуулна.

Ажлын хэсэг дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандарт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхэд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд чанарын байдалд холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулж болно. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг эрүүл ахуйн болон галын аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан агуулахад технологийн дагуу түр хадгална.

Шаардлагатай тохиолдолд дотоодын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч этгээдийн агуулахад түр хугацаагаар хадгалуулж болох бөгөөд уг агуулах нь стандартын шаардлага шаардлагыг хангасан байна.

Хадгалалтын тусгай горим, технологи шаардсан тусламжийн бараа, материалыг аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан хадгалуулж болох бөгөөд гэрээнд барааны чанар, стандарт, хадгалах хугацаа, төлбөр, барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, талуудын хүлээх хариуцлага, мэдээ тайлангийн талаар тодорхой тусгасан байна.

Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг аж ахуйн нэгж, байгууллагаас тусгайлан нэр зааж ирүүлэхээс бусад тохиолдолд хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилан олгох асуудлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутагт тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу тухайн шатны Засаг дарга дотоодын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хуваарилах, олгох ажлыг шуурхай зохион байгуулж, үр дүнг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх асуудлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тухайн орон нутгийн Засаг дарга хариуцна.

Дотоодын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал хүсэлт гаргасан тохиолдолд үзүүлсэн тусламжаа хуваарилах, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулж болох бөгөөд холбогдон гарах зардлаа өөрөө хариуцаж, тухайн шатны Засаг дарга болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг хадгалах, тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны зардал, тайлан бүртгэл

Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авч байршуулах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх болон бусад үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ

Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дотоодын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулсан тухай тайлан мэдээг нэгтгэн, дотоодын хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн аж ахуйн нэгж, холбогдох байгууллагад албан бичгээр тайлагнаж, олон нийтэд цахим хуудас болон хэвлэл

мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлнэ.

Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутагт онцгой байдлын байгууллага хэрэгжүүлнэ.

Орон нутагт хуваарилсан дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтад Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

Харин олон улсын хүмүүнлэгийн тусламжийг гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн олон улсын хүмүүнлэгийн тусламж авах саналыг Улсын онцгой комисс Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ. Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан бол Засгийн газар уг тусламжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.

Жишээлбэл: Гамшгийн хор уршиг, хохирол үндэсний эдийн засаг, нийгмийн нөөц боломж, чадавхаас давсан тохиолдолд олон улсаас хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг хүсэх уриалгыг Засгийн газар гадаад улс, олон улсын байгууллагад гаргана. Үүний дагуу зудын гамшгийн үед Засгийн Газраас Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Олон Улсын Төрийн Бус Байгууллагуудад хандан хүсэлт тавьдаг.

Монгол улсад гамшиг осол тохиолдсон үед хамгийн түрүүнд тус улсад үйл ажиллагаа явуулж буй Олон Улсын Төрийн Бус Байгууллагууд туслалцаа үзүүлдэг бөгөөд Гадаадын Иргэн, Харьяатын Газраас гаргасан судалгаагаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллага, салбар төлөөлөгчийн газар зэрэг 90 гаруй байгууллага албан ёсоор бүртгэгдсэн байдгийн 40 хувь нь буюу 36 нь зөвхөн халамж, хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тэдгээр ОУТББ-ууд нь зудын гамшгийн үед гамшигт нэрвэгдсэн малчдад дараах нэр төрлийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

### Хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааны хэлбэрүүд<sup>28</sup>

*Мөнгөн тусламж.* Цаг агаарын өөрчлөлтөөс шалтгаалан өвөлжилт хүндэрч, малчид орлогын эх үүсвэр болох малаа их хэмжээгээр алдах, орлого багатай айл өрхүүд малын тэжээл болон хоол хүнс, эм тариа, хүүхдүүдийнхээ хичээлийн хэрэгсэл зэргийг авч чадахгүй байгаа зэргээс шалтгаалан тодорхой хэмжээний бэлэн мөнгөний тусламжийг малчдад үзүүлэх болсон. Мөнгөн тусламж нь манай орны хувьд шинээр бий болж, сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр юм.

Аливаа төрлийн гамшиг, өлсгөлөнгийн үед хүмүүст тулгардаг томхон бэрхшээл нь хоол хүнс худалдан авах санхүүгийн чадамжгүй болдогтой холбоотой байдаг тул мөнгөн орлого хүмүүст хуваарилснаар хэрэгцээг нь шийдэж болно гэж эдийн засагч, философич Амартаяа Сений “entitlement” онолоор авч үздэг.

Гамшигт өртсөн хүмүүс орлого олохын тулд ажил хайхаар өөр бүс нутагт нүүн очих, өөрт байгаа эд хөрөнгөө зарах болон биеэ үнэлэх, хууль бус үйлдэл болон хүчирхийлэл үйлдэх гэх мэт зүйлсийг түгээмэл хийдэг.

Мөнгөн тусламжийн сургалт, түншлэлийн олон улсын байгууллагын (МТСТОУБ) тодорхойлсноор МТХ гэдэг нь мөнгө эсхүл аливаа нэг үйлчилгээ бараа, бүтээгдэхүүн авах эрхийн бичгийг гамшигт өртсөн хүмүүст шууд өгөх хөтөлбөрийг хэлнэ.

Харин “Sphere” төсөл буюу “Хүмүүнлэгийн дүрэм ба хариу арга хэмжээний босго стандарт”-ын хүнсний аюулгүй байдал хэсэгт МТХ хэрэгжүүлэх заавар оруулж өгснөөр

хүмүүнлэгийн байгууллагууд болон хандивлагч нарын дунд илүү хүлээн зөвшөөрөгдөж байна.

Жишээ нь: Эдийн засгийн хамтын ажиллагаат орнуудын (OECD) Хөгжлийн тусламжийн хорооны (DAC) хандивлагч нарын хүмүүнлэгийн хямралт нөхцөлд МТХ-д өгч буй санхүүжилтийн дүн сүүлийн таван жилд эрс нэмэгдсэн байна.

Түүнчлэн нийгмийн шинжлэх ухааны хүрээнд судлаачдын сонирхлыг ихэд татдаг сэдэв болсон (Дэлхийн Банк) МТХ нь дотроо эрхийн бичиг (ваучер) тараах, нөхцөлт бус мөнгөн тусламж, тодорхой нөхцөлт мөнгөн тусламж, ажил хийлгэж мөнгө өгөх гэх мэт байдаг ба тухайн орон нутгийн нөхцөл байдлаас хамаарч тохирох аргыг хэрэглэдэг.

МТХ нь дараах давуу талтай. Үүнд:<sup>29</sup>

1. Гамшгийн нөхцөл байдлыг хувь хүн өөрөө удирдах эрх мэдлийг өгдөг
2. Уян хатан байдал ба сонгох эрх
3. Орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөө
4. Зардал хэмнэлт, үр ашигтай байдал
5. Салбар бүрд хийх боломжтой (хүнс, орон байр, боловсрол гэх мэт)

*Хүнс тэжээлийн тусламж, Амьжиргааг хамгаалах тусламж.* Манай орон нүүдлийн мал аж ахуйтай тул малчдын амьжиргааны эх үүсвэр болох малыг хамгаалахын тулд малын өвс тэжээл, малын сувиллын багцын тусламж (витамин, эрдэст долооц, төлийн сүү орлуулах тэжээл, загасны тос, аминдэмийн нэмэгдэл, шархны тос, малын нүдний түрхлэг, хачиг, ширх, шалзны эсрэг дусаалга зэрэг) малын эм тариагаар туслах, ингэснээр малын хүч тэнхээ, бэрхшээлийг давах чадварыг сайжруулна.

Энэ нь малчид малтайгаа үлдэх нэг боломжийг бүрдүүлж байгаа явдал юм. Мөн малаа алдсан малчдыг амьжиргааны эх үүсвэртэй болгох зорилгоор тодорхой тооны малыг малчдад буцалтгүй тусламж хэлбэрээр өгөх.

*Эрүүл мэндийн тусламж.* Эм тариа, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий дэмжлэг. Өвөлжилт хүндэрч, зам харгуй цасанд боогдсоноор малчид эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй болох, малынхаа араас анхаараад өөрсдийнхөө эрүүл мэндийг үл хайхрах болсоноор эрүүл мэнд нь муудах, отроор өөр сум орон нутагт очсоноор эмнэлгийн тусламж үйлчилгээнээс холдох, зам харгуй цасанд боогдсоноор эмч эмнэлгийн мэргэжилтэнүүд малчдад тусламж үзүүлдэхэд нь бэрхшээл тулгарах, санхүү төсөв нь энгийн үеэс илүү шаардагдах гэх мэт хүндрэлүүд гарч байгаа тул тухайн сум орон нутгийн эмч, эмнэлгийн багийг малчдын өрх гэр, отор нүүдэл хийж буй орон нутагт нь очиж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл бололцоог хангах зорилгоор автомашины сэлбэг, шатахууны болон эм, тарианы зардлын тусламжийг үзүүлсэн байна.

*Нөхөн боловсрол олгох хөтөлбөр:* Зудын үед малчид хүн бүл дутмаг болдог тул ахлах ангийн болон эрэгтэй хүүхдүүдээ хичээлээс тасалдуулж дайчлах асуудал их гардаг. Мөн отор нүүдэл хийн сургууль, төв суурин газраас холддог тул хүүхдүүдээ сургуульд нь хүргэж өгөх боломжгүй болдог. Эдгээрээс шалтгаалаад малчдын хүүхдүүд хичээлээсээ хоцрох, сургууль завсардах асуудал гардаг. Түүнчлэн эцэг эх нь отроор явсан, зудын хүндрэлээс шалтгаалаад эцэг эх нь эргэн ирэх боломжгүй байгаа айлын хүүхдүүд хичээлээсээ хоцрох, гэрээ санах зэрэг сэтгэлзүйн бэрхшээлд орох асуудал гардаг байна. Иймд тэдгээр хүүхдүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хоцрогдолыг арилгах, боловсрол нөхөн олгох сургалтанд хамруулж байна.

**Бусад:** Зудад мал ихээр хорогдож, энэ нь цаг агаар дулаарах үед муудаж үмхийрэх, цаашлаад халдварт өвчин үүсгэх эрсдэлийг бий болгодог тул малын сэг зэмийг яаралтай зайлуулах шаардлага гардаг. Үүнд сум орон нутаг, улсын нөөцөөс санхүүжилт үзүүлдэг ч хангалттай хүрдэггүй тул олон улсын байгууллагуудад хандан тусламж авах тохиолдол байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын төрөлжсөн байгууллагууд болон Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудаас бүрдсэн 12 кластер бүхий олон улсын хүмүүнлэгийн баг 2011 оны 1 сард байгуулагдан ажиллаж байна. Тус багийг НҮБ-ын Суурин Төлөөлөгчийн Газар удирдан гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл солилцох, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, кластер тус бүрээр бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах ажлыг хийдэг.

### Хүмүүнлэгийн хандив, тусламжийг тараах хүргэх үед тулгарч буй бэрхшээлүүд: 31

Дотоод болон гадаадын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлэхэд зарим нэг саад бэрхшээлүүд гардаг.

Төрийн байгууллагын холбогдох албан тушаалтны өөрчлөлт, Кластер болон яамд, улсын албадын хоорондын уялдаа муу. Монгол улсын гамшгаас хамгаалах бүтцэд кластерийн зохицуулалт тусгагдаагүй, кластеруудыг чиг үүрэг тодорхой бус, ялангуяа орон нутгийн түвшинд. Мэдээллийн менежментийн дата бааз байхгүй. Аймаг, сумдад хүмүүнлэгийн тусламжийн давхардал болон дутагдал их ажиглагдсан. /Зарим сумдад нэг өрх хэдэн хэдэн байгууллагын тусламжийг авч байхад зарим өрх ямар ч тусламжгүй үлдэж байх гэх мэт/ Бодит тоо баримт, бүртгэл мэдээллийн сан сул, өөрөөр хэлбэл мэдээллийн дата бааз сул.

Гамшгийн нөхцөл байдлын үнэлгээ, зохицуулалт удаан, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, эрсдэлийн үнэлгээний аргачлал байхгүй, орон нутгийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сул, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан судалгаа сул, төрийн албан хаагчдийн ур чадвар сул байгаа зэрэг бэрхшээлүүд гардаг. Цас ихтэй газруудад иргэдэд эрүүл мэндийн болон нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл гарч, мал бэлчээрлэх боломжгүй, орон нутгийн чанартай зам даваа муу, цасанд хаагдсан, иргэдэд эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ үзүүлэх автомашин дутагдалтай, зарим нь эвдэрч гэмтсэн байдаг.

Гоц халдварт өвчний хорио цээрийн үед тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны зардалгүй, хуримтлагдсан өртэй /эмнэлгүүд болон сум орон нутаг нь шатахуун нийлүүлэгч компанид өртэй байх, түүнээсээ шалтгаалаад томилолтоор явж үйлчилгээгээ үзүүлж чадахгүй байх гэх мэт/ орон нутгийн сонгуультай холбоотой нутгийн захиргааны байгууллагуудын зохион байгуулалт, харилцан ажиллагаа, шийдвэр гаргах хугацаа удааширсан зэрэг мөн орно.

Орон нутагт хүмүүнлэгийн тусламж, туслалцааг үзүүлэх өрхийн судалгаа сонголт буруу хийгдэх. Малчид банкны зээл авах зорилгоор малын “А” дансаа бодит бус бүртгүүлдэг нь тэдний өрхийн орлогыг бодит бус болгодог, тусламжаас хоцрох, хүмүүнлэгийн байгууллагуудын шалгуур үзүүлэлтүүдийг хангах нөхцөлийг бүрдүүлж чаддаггүйн улмаас хүмүүнлэгийн тусламжаас хоцордог байна.

Тусламж тараах ажлын хэсэгт ажиллаж буй орон нутгийн төр захиргааны байгууллагын ажилтнуудын шудрага бус байдлаас шалтгаалан тусламж зохих эзэндээ хүрч чаддаггүй. Учир нь тэд ажилдаа шудрага хандах бус, танил тал, ах дүү хамаатан,

төрөл, саднаа оруулах хандлага их гаргадаг нь тусламж эзнээ олж, хүрч чадахгүй байдлаас тухайн олон улсын хүмүүнлэгийн байгууллагын тусламжийг тухайн орон нутагт дахин авах боломжийг хаах хүртэл сөрөг үр дагавар авчирдаг байна.

Улс төржүүлэх. /Хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх хугацаа нь орон нутгийн сонгуулийн үед давхацсан нь зарим суманд өөрийн намын малчин өрхийн нэрсийг ирүүлэх, өөрийн сурталчилгаанд ашиглахыг оролдох гэх мэтээр улс төржүүлэх асуудал орон нутагт гарч байсан нь олон улсын хүмүүнлэгийн тусламжийг тараахдаа улс төржүүлэхгүй байх, ялгаваргүй хандах гэсэн зарчмыг зөрчих үндэслэл болдог байна. Ингэснээр тухайн сум орон нутаг дахин хүмүүнлэгийн тусламж авах болзол, боломжийг хаадаг/

Дотоодын буюу иргэдийн үзүүлж буй тусламжийг хүлээн авах, хадгалах, зохион байгуулах газар байдаггүй, үүний тулд хаана хэнд хандах ёстой вэ? гэдэг мэдээллээр иргэд их дутмаг байдаг бөгөөд энэхүү тусламжийг зөвхөн ОБЕГ-ын үүрэг мэт буруу хандлага гаргадаг, эсвэл олон улсын байгууллагууд руу хүргэх, сум орон нутаг руу ямарч хяналт зохион байгуулалтгүй хүргэх, нэг сум багт тусламжийн давхардал үүсэх гэх мэт алдаа гаргадагаас хүмүүнлэгийн тусламж нь хэрэгтэй хүндээ хүрч буй эсэх нь тодорхойгүй, бас хяналтгүй, үр дүнгүй болдог. Мөн малчдын хэрэгцээ шаардлагыг судалж үзээгүй, зохион байгуулалт, тааруу байдгаас зарим тохиолдолд шаардлага хангахгүй, хэрэгцээгүй бараа бүтээгдэхүүн цуглуулах, эсвэл нэг төрлийн бараа бүтээгдэхүүний бөөгнөрөл үүсэх хандлага гардаг байна.

Зам тээвэр дэд бүтэц тааруу хөгжсөн, ялангуяа газар хөдлөлтийн 4 том хагаралын төв цэгийн дунд байрлах, хүн амын нягтаршил ихтэй, замын

хөдөлгөөний түгжрэлтэй Улаанбаатар хотод газар хөдлөлт болсон нөхцөлд хүмүүнлэгийн тусламж хүлээн авахад хамгийн түрүүнд хүндрэл гарч болзошгүй. Учир нь одоогийн нисэх буудлын багтаамж хүрэлцээ муу, ганцхан нисэх буудалтай

Улаанбаатар хот руу нэвтрэх зам гүүр цөөн, их хэмжээний хүмүүнлэгийн тусламж туслалцааг хүлээн авахад шаардлага хангасан томоохон агуулах байхгүй. Газар хөдлөлт болсон үед иргэдийг олноор байрлуулах, нүүлгэн шилжүүлэх байрны хүрэлцээ тааруу, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд эмнэлгүүдийн хүчин чадал хүрэхгүй байх хүндрэл тулгарах, цогцос хадгалах хангалттай байр сав байхгүй.

Мөн гэр хорооллын хашаа байшингууд нь шавааралдсан байрлалтай, нэг хашаанд олон айл байрлаж байгаа нь газар хөдлөлтийн үед томоохон хэмжээний галын аюул нүүрлэх эрсдэлтэй.

Мөн сум, баг хоорондын зам тээвэр муу хөгжсөн байдаг, өвлийн улиралд цаг уурын хүндрэл нь хүмүүнлэгийн тусламжийг цаг хугацаанд нь хүргэхэд сөргөөр нөлөөлдөг байна.

Түүнчлэн донор, хандивлагчдын санхүүжилтээр гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон аймаг, сум, багийн иргэдэд хүмүүнлэгийн тусламжийг яаралтай үзүүлэх төсөл, хөтөлбөр нь хэрэгжүүлэхэд богино хугацаанд хийж гүйцэтгэх шаардлага тавигддаг нь манай орны цаг агаар, орон нутгийн нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг учраас найдвартай тээвэрлэлт, хадгалалт, зохион байгуулалт чухал байдаг.

Их хэмжээний худалдан авалт хийх нөхцөлд дотоодын томоохон нийлүүлэгч компаниуд цөөхөн тул импортын барааны нийлүүлэлтээс хамааралтай хугацаа алдах эрсдэл үүсдэг.

## ДҮГНЭЛТ:

Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллага, төрийн болон улсын албадуудын хамтарсан гамшгаас хамгаалах дадлага сургуулилт хийгдэж байгаа хэдий ч түүнд хамрагдах улсын албад, иргэд, аж ахуйн нэгжийн идэвхи оролцоог улам нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

МТХ-ийн үед тулгарсан бэрхшээл гэвэл тухайн хандив тусламж нь хугацаа заасан, богино хугацаанд үзүүлэх шаардлагатай байдаг тул цаг хугацааны хувьд шахуу байх, малчид банкинд зээлтэй байх, банктэй гэрээ байгуулах, малчдын хувийн мэдээлэл зөрүүтэй байх, орон нутгийн удирдлагууд МТХ-ийн талаар буруу ойлголттой байх, сөргөөр ашиглахыг оролдох, тусламж хүлээн авагчидтай холбогдож хяналт тавихад хүндрэлтэй

байх гэх мэт бэрхшээлүүд тулгарч байв. Ялангуяа ажлын ачаалал болон ашгийн хэмжээнээс шалтгаалан банкны зүгээс МТХ-т оролцох сонирхол маш бага байна. Иймээс хүмүүнлэгийн тусламж үйлчилгээг оновчтой хэрэглэх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй байна.

### Ашигласан материал

1. Legalinfo.mn
2. Гамшгийн тухай хууль
3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал. 2017 онол  
практикийн бага хурал
4. <https://mn.wikipedia.org>
5. <https://www.redcross.mn>
6. <http://newswall.mn> ›